



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

“Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоо,
цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог нэгдүгээр, цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. “Илч-Орд” ОНӨААТҮГ-ын захиралтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

3. Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон цалингийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Д.Гантулга)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоо цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай” А/11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ